



Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Улаанбаатар  
Вайнштепаны мэргэжлийн их сургууль, Фрайзинг  
хоорондын хамтран ажиллах

### ГЭРЭЭ

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (цаашид ХААИС гэх), ХБНГУ-н Бавари мужийн Вайнштефаны мэргэжлийн их сургууль (цаашид ВМИС гэх) хоёр талын эрдэм шинжилгээний болон боловсролын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд тэгш эрхийн зарчимд тулгуурлан доорх агуулга бүхий гэрээг байгуулав.

#### I

Энэхүү гэрээний хүрээнд ХААИС болон ВМИС нь дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагаа
- Хамтарсан судалгаа, шинжилгээ явуулах
- Шинжлэх ухааны чиглэлээр мэргэжил дээшлүүлэх
- Эрдэм шинжилгээний бүтээл, сургалт, судалгааны талаар мэдээлэл солилцох

#### II

Эдгээр хамтын ажиллагаа нь дараах хэлбэрээр хэрэгжинэ:

1. Дадлагын оюутны харилцан солилцооны дагуу 20 хүртэл дадлагын болон оюутаны солилцоог хийж сургалтанд хамруулах, хэрэв сургалт нь жил хүртлэх хугацаатай байвал сургалтын төлбөр төлөхгүй байна.
2. Багш, судлаач, мэргэжилтэн нарыг харилцан солилцох

3. Хоёр тал хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар төр засаг, Европын холбоо болон бусад байгууллагаас дэмжлэг авахад харилцан туслах
4. Сургуулиуд хамтран сургалт, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлнэ.
5. ХАА-н Бизнесийн удирдлагын магистерийн /MBA/ сургалтыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх мөн ВМИС-ийн жишгийн дагуу ХААИС дээр үүсгэн бий болгох
6. Цаашдын хамтын ажиллагааг дор дурьдсан чиглэлээр өргөжүүлнэ.
  - а. Хөдөө аж ахуйн маркетинг, менежмент
  - б. Хөдөөгийн хөгжил
  - в. Үйлдвэрлэл бизнесийн чиглэлээр хамтарч ажиллах

### III

Гэрээний хүрээнд хамтран хэрэгжүүлэхээр заасан үйл ажиллагаанд ажлын төлөвлөгөөг хавсаргах ба үүнийг хоёр тал харилцан тохирч шийдвэрлэнэ.

### IV

Уг гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх ба шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэрээг сунгах болон цуцлах асуудлыг хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Захирал  
Доктор, профессор  
Херман Хайлер

Ректор  
Академич, Профессор  
Бадарчийн Бямбаа

---

---